

## Өрөөндөө сүлжээний төхөөрөмж болон IP утастай өөрийн сүлжээгээ холбох бол

1. Хэрвээ та өрөөндөө switch эсвэл router залгаж байгаа бол гаднаас орж ирж байгаа холболтоо/LAN-ийн утасаа/ switch эсвэл router-ний **Ethernet** эсвэл **WAN** гэсэн нэртэй холболтонд нь залгана.
  - a. Таны сүлжээний төхөөрөмжийн оролт **WAN** болон **LAN1,LAN2, ...** гэсэн нэршилтэй байвал **WAN** оролтод гаднаас орж ирсэн холболтоо залгана, бусад оролтод компьютерлуу залгах холболтоо залгана.
  - b. Таны сүлжээний төхөөрөмжийн оролт **Eth** болон **LAN1,LAN2, ...** гэсэн нэршилтэй бол **Eth** оролтод гаднаас орж ирсэн холболтоо залгана бусад оролтод компьютерлуу залгах холболтоо залгана.

Ингэснээр сүлжээний хаягжилт зөв явагдах ба хэрвээ буруу залгасан бол өрөөнд байгаа интернет холболтын төхөөрөмжүүд болон компьютерүүд буруу хаяг авч сүлжээний алдаа гарч интернетэд холбогдох боломжгүй болохыг анхаарна уу!!!.

2. Хэрвээ та интернет холболтоо утаснаасаа авсан бол утсан дээрх оролтын хэсэгээ харна уу!!!
  - a. Утсан дээрх холболтын хэсэг **WAN** болон **LAN** гэсэн оролттой байвал гаднаас орж ирсэн холболтоо **WAN** оролтод залгаж, компьютерлуу залгах холболтоо **LAN** оролтод залгана.
  - b. Утсан дээрх холболт хэсэг **LAN** болон **PC** гэсэн оролттой байвал гаднаас орж ирсэн холболтоо **LAN** оролтод залгаж, компьютерлуу холбох холболтоо **PC** оролтод залгана.